МОНГОЛ УЛС
**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**
14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2021.02.10 № 05/1762
танай ____________-ны №____________-т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА М.БАЯРСҮХ ТАНАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай

Тус сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Ганбаатарын Угантуяагийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчилтэй гэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Г.Угантуяа нь Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т "... тусгай шалгалт /тухайн албан тушаалын/-ыг мөн хуулийн 27.1.1-т заасан төрийн албан хаагчаас ... авна", мөн Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2-т "Зөвлөл, Салбар зөвлөл нь сонгон шалгаруулалтын тайланг хянаж, шалгалтаар хамгийн өндөр оноо авсан иргэнийг албан тушаалын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлнэ" гэж заасныг тус тус зөрчихөөр байна.

Иймд тус албан тушаалд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн түр болон жинхлэн томилох асуудлыг шийдвэрлэнэ үү.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР Х.ХАШБААТАР

ЗДТГ-ын дарга
С.Нарантуяа
Г.Угантуяаг санхүү ТС дарга албанд түр томилох бэ.
СЗ 8 02/21.

0004502